

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-ний ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-04-30

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 05 дугаар сарын 06-ны “Мягмар” гарат** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2026 онд шинээр баригдах Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн байршил, хамран сургах тойрог, хамрагдах хүүхдийн тоо зэргийг нарийвчлан тодорхойлох чиглэл өгөгдсөний дагуу дүүрэгт шинээр баригдах сургуулийн зураг төсвийг яаралтай батлуулахад анхаарах.	НХХ, Боловсролын хэлтэс
2	“Хотын иргэдийн баяр-Хүрээ даншиг” наадмын захирамжийг гаргаж, зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах чиглэл өгөгдсөний дагуу бэлтгэлийг сайтар ханган идэвхтэй оролцох.	НХХ, Соёлын ордон, БТСХ
3	Нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний зам талбайд удаан хугацаанд байршуулсан автомашиныг журамлах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах.	ТХҮХ, Цагдаагийн хэлтсийн ЗЦХ
4	Эзэмшил газраа зориулалтын бусаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хуулийн дагуу мэдэгдэл хүрүүлэх ажлыг зохион байгуулах.	ГЗБА
5	Нийслэлийн Засаг даргаас хороодын Засаг дарга нарт өгсөн үүрэг даалгавар, түүний хэрэгжилтийн тайланг сонсох ажлыг зохион байгуулахтай холбогдуулан үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлан биелэлтийн хамгаалалтад анхаарч оролцох.	Хороод

6	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/379, А/509 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, татварын ногдол, өрийг төсөвт төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулах.	СТСХ, Татварын хэлтэс
7	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш хөрөнгө оруулалтын ажилд шинээр гэрээ байгуулах боломжгүй болж байгаатай холбогдуулан худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх.	ХААА, (ЕБС, СӨББ)
8	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд өөрсдийн хийж хэрэгжүүлж буй ажлуудаа иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулах.	ТЗУХ, Нийт байгууллагууд
9	Соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалж, урлаг, соёлын үзвэр, үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах.	НХХ, Соёлын ордон
10	Авто замын тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэх, засварлах, байршуулах ажлуудаа эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
11	Дүүргийн нутаг дэвсгэрт барилгын суурийн нүх ухсан байршлуудын судалгааг гарган, цэгцэлж орчны аюулгүй байдлыг хангуулах ажлуудыг зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ГЗБА
12	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрлийн болон бусад шон дээгүүр татсан кабель утас, өнгө үзэмжгүй самбар зэргийг цэгцлэх ажлуудыг шуурхай зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
13	Ой, хээрийн түймэр, ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах.	ОБХ
14	Дүүргийн хэмжээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Дотоод аудитын алба, Нийт байгууллагууд
15	Дүүргийн хэмжээнд үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг гадна орчноо угаах, өнгө үзэмжийг сэргээх, хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Нийт байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
16	Хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх.	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, БТСХ, Соёлын ордон
17	Нийтийн эзэмшлийн орон сууцны байрнуудын дэргэдэх авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээнд байрлуусан машинуудыг цэгцлэх, журамлах ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтсийн ЗЦХ
18	2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдах “Багахангай марафон-2025” УАШТ-ий бэлтгэлийг сайтар хангаж, тэмцээний үеэр ашиглагдах нийтийн зориулалттай Ариун цэврийн байгууламжийн цэвэрлэгээ, үйлчилгээнд анхаарч ажиллах.	НХХ, БТСХ, Илч-Орд ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд
19	“Багахангай лиг-2025” тэмцээний хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэлийг ханган ажиллах.	НХХ, Соёлын ордон, БТСХ
20	2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Төмөр замын “Хангай” зөрлөгт зохион байгуулагдах өдөрлөгийн арга	ЗДТГ, Соёлын ордон, ЖДҮҮДТ,

	хэмжээний бэлтгэлийг сайтар хангаж ажиллах. (Явуулын ариун цэврийн байгууламжийг байршуулах)	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд
21	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 05 дугаар сарын 10-ны өдөр дүүрэгт зохион байгуулагдах мод тарих арга хэмжээнд идэвхтэй оролцох.	ЗДТГ, Нийт байгууллагууд
22	Хороод тус бүрт “Халуун сүүгээр үйлчлэх цэг”-ийг байгуулан, үйлчилгээг эхлүүлэх.	ТХҮХ, Хороод
23	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГЭРЭЛЦОЛМОН

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР